



БАРИЛГА. ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

15171 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.
Их тойруу-1, Утас/Факс: 32-07-34.
E-mail: info@barilga.gov.mn

2018.04.12 № 1/574

танай _____ -ны № _____ -т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ-Д

Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 6
дугаар хорооны нутаг дэвсгэрт байрладаг "Эрүүл
мэндийн хөгжлийн төвийн эмч нарын 2 дугаар
байр" 60.0м x 14.0м хэмжээтэй, 4 давхар барилгын
ашиглалтын явцтай газар дээр очиж танилцсан
ажлын хэсгийн тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ... хуудас.



201801206

АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН

2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 329 дугаартай Эрүүл мэндийн хөгжлийн төвийн өрөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамцийн албан бичгийн дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт 1960 онд ашиглалтад орсон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмч нарын 2 дугаар байр болох 60.0м × 14.0м хэмжээтэй 4 давхар өрөт бүтээцэн хийцтэй, шувуун нуруу дээвэртэй барилга дээр Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн ахлах инженер, мэргэшсэн инженер С.Сүхтуяа, барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер, мэргэшсэн инженер М.Гомбосүрэн, барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер Д.Тулга, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хангамж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Ч. Тунгалаг, жижүүр Б.Оюунбат нар барилга бусад холбогдох материалтай танилцав.

Нэг: Барилгын ажил

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмч нарын 2 дугаар байрны фасад, гадна ханын шавар шохой ховхорч унасан, агааржуулалт хэвийн ажилладагтүүгээс 1,2,3,4 дүгээр давхруудын өрөөнүүдийн хана таазны шавар шохой унаж мөөгөнцөртсөн мөн 1 дүгээр давхрын архивын өрөөний дотор засал чимэглэлийн шавар шохой ховхорч унасан, хананд хагарал ан цав үүссэн, хаалга, цонхны битүүмж алдагдаж хэв гажилт үүсч, дулаан алдагдал ихтэй байна.

"Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар" БДЗ1.102.00 дүрмийн 2.4т заасныг, "Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх /барилга байгууламжийг ашиглалтын явцад өмчлөгч, эзэмшигчийн үүргийн/, 11 дүгээр зүйлийн /барилгын үйл ажиллагаанд баримтлах гэсэн/ тус тус заалтын хангахгүй байна.

Цаашид барилгын үндсэн хийц, бүтээцийг өөрчлөхгүйгээр барилга байгууламжийг засварлах, түүнд суурилуулсан цэвэр, бохир ус уур, хий, дулаан цахилгаан, механик тоног төхөөрөмжийг техникийн үзүүлэлтийг бууруулахгүйгээ ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор элэгдэж хуучирч, эвдэрсэн тоно төхөөрөмжийг солих зэрэг засварын ажлыг гүйцэтгэхээр байна.

Хоёр: Дотор гэрэлтүүлэг хүчит төхөөрөмж, дотор холбоо дохиолол

Тус барилга нь одоо байгаа ХТП-ээс 0.4 кВ-ын кабель шугамаар тэжээгдэж байна. Барилгын өрөнхий щитийг шинэчилэн засварлаж электрон тоолуур болон автоматаа тоноглосон байна.

Барилгын дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмжийн болон дотор холбоо дохиоллын далд монтаж нь удаан жилийн элэгдэл болон ус, чийгнээс болж гэмтсэний улмаас ихэнх утаснуудыг илээр явуулсан байна. Мөн холбоо дохиоллын шугам сүлжээ нь ашиглалтын шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй байна. Энэ нь барилгын тухай хууль болон галын норм дүрэм болон аюулгүй ажиллагааг ноцтой зөрчиж байна.

Иймээс Цахилгаан байгууламжийн БД43-101-03 дүрмийн 2.1-ийн дагуу дотор гэрэлтүүлэг, хүчит төрөөрөмжийн кабель шугам, тоноглолыг засварлаж угсрах шаардлагатай байна.

Гурав: Инженерийн шугам сүлжээ

Барилгын дотор сантехникийн систем нь эвдрэл, гэмтэл, кросст, орсон шугам удирдах зангилааны анхны хаалт, хурданы ус халаагуур байхгүй. Барилга байгууламж инженерийн шугам сүлжээний засвар ашиглалтын хугацааны жишиг норм БНБД13-04-03-ийн 2.5-т барилга байгууламжийн бүрдэл хэсгийн үр ашигтай ашиглалтын хугацааны хамгийн бага үргэжилэлийг хүснэгт 2 заасныг, дотор сантехникийн систем БНБД40-06-16, барилга байгууламжийн галын аюулгүйн байдал БнбБ21-01-02 дээрх норм дүрэмийг хангахгүй байна.

Тайлан бичсэн:

С.Сүхтуяа

М.Гомбосурэн

Д.Тулга